



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 02 өдөр

Дугаар

А/170

Хэрлэн сум

Арга хэмжээ зохион байгуулж,
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хорин гуравдугаар хуралдааны 2023 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.3.6.1 дэх заалтад заасны дагуу “Зүүн бүсийн аварга шалгаруулах” арга хэмжээг зохион байгуулахад зориулж 13,000,000 (арван гурван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, шаардагдах зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Арга хэмжээнд шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Ж.Энх-Амгалан)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ж.Гантулга)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны
дүгээр сарын 02-ны өдрийн
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Ажлын хэсгийн ахлагч:	Ж.Энх-Амгалан	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Г.Оюун-Эрдэнэ	Хүнс, хөдөө аж ахуйн газрын Үйлдвэр үйлчилгээний албаны дарга
Гишүүд:	Г.Ариунчимэг	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн
	Д.Должинсүрэн	Соёлын үйл ажиллагаа, биеийн тамир, спортын бодлого хариуцсан мэргэжилтэн
	Г.Нэргүйбаатар	Биеийн тамир, спортын газрын дарга
	Д.Цогт-Эрдэнэ	Хэнтий аймгийн Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулгын дарга
	Ж.Ганчимэг	Хүнс, хөдөө аж ахуй газрын хөнгөн болон жижиг дунд үйлдвэрлэл, ахуй үйлчилгээ, хошооний асуудал хариуцсан мэргэжилтэн
	С.Болд	“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн харъяа Хэнтий Цахилгаан түгээх сүлжээ салбарын дарга
	М.Бямбатогоо	Хэнтий аймгийн Үсчин гоо сайханчдын холбооны тэргүүн